



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/331

Чингис хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн хурлын тэмдэглэл, үнэлгээний хорооны 03 дугаартай тайлан зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд зарласан “Хүнсний ногооны зоорь шинээр барих” тендерт “Эн Би Жи” ХХК-ний тендерийн баримт бичиг “Хамгийн сайн” үнэлэгдсэн дүгнэлтийг Үнэлгээний хорооноос ирүүлсэн тул тус аж ахуйн нэгжид гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Тендерт шалгарсан “Эн Би Жи” ХХК-тай “Хүнсний ногооны зоорь шинээр барих” ажлын гэрээг тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан байгуулж ажиллахыг аймгийн Хөдөө аж ахуйн газар (Ж.Энх-Амгалан), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011724